



MONGOLIAN ORGAN
TRANSPLANTATION ASSOCIATION
The First Central Hospital Building, S.Zorig street-2,
Sukhbaatar district, 1 khoroo, Ulaanbaatar city, Mongolia 210648
Tel: 973-99115824, 976-99097305
E-mail: secretary@mota.mn
Website: http://mota.mn
2023 05. 23 № 2023 - 01

таныгны №.....т

Эрхтэн шилжүүлэн суулгалтын
VIII хуралд оролцуулах, илтгэл
хүлээн авах тухай

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ,
ЭМЯ-НЫ ХАРЪЯА ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ
МЭРГЭШЛИЙН ТӨВ, МОНГОЛ-ЯПОНЫ
ЭМНЭЛЭГ, БОЭТ, АЙМАГ, ДҮҮРГИЙН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА,
ЗАХИРАЛ НАРТ

Жил бүр уламжлал болон явагддаг “Монгол-Солонгосын хамтарсан эрхтэн шилжүүлэн суулгалтын VIII хурал”-ыг 2023 оны 07 сарын 06-07 өдрүүдэд “Ёс зүйг дээдлэн – эрдэнэт амийг аварья” уриатайгаар зохион байгуулагдах гэж байна.

Тус 2 кредитын хурлаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний ололт амжилтыг дүгнэх, цаашид нэвтрүүлэх шинэ технологиудын талаар хэлэлцэх, Солонгос судлаач, эмч нараас туршлага судлахаас гадна энэ жилийн онцлог нь ёс зүйн талаас тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэхэд оршино.

Та бүхнийг өөрийн байгууллагын эмч, судлаач, эмнэлгийн ажилчид болон суралцагчдыг бидний зохион байгуулж буй хуралд идэвхитэй оролцуулж, илтгэлээ ирүүлнэ үү. Хугацаандаа, шаардлага ханган ирүүлсэн илтгэл бүр сэтгүүлд хэвлэгдэх болно.

Материал хүлээн авах:

- Сүүлийн хугацаа: 2023 оны 06-р сарын 19-ны 17:00 цаг хүртэл
- Email: mkot20230706@gmail.com
- Холбоо барих утас: 95346381, 96687536

Жич: Эрхтэн шилжүүлэн суулгалтын Монголын сэтгүүлд хэвлэгдэх илтгэлийн хураангуйд тавигдах шаардлагыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудас

ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАЛТЫН
МОНГОЛЫН ХОЛБООНЫ ТЭРГҮҮН



[Handwritten Signature]
Д.НЯМСҮРЭН

МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАЛТЫН VIII ХУРАЛ

Үндэслэл

Монгол улсын анагаахын шинжлэх ухаанд гарсан томоохон ололт амжилтуудын нэг нь эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг амжилттай нэвтрүүлж нутагшуулсан явдал юм. 2006 оноос бөөр шилжүүлэн суулгах эмчилгээг хийж эхэлсэн бөгөөд өдгөө 300 гаруй, 2011 оноос элэг шилжүүлэн суулгаж эхлэн одоогоор- 200 гаруй, 2014 оноос ауто-цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийж эхэлсэн ба 31 хүнд шилжүүлэн суулгаад байгаа билээ. Мөн цусны бүлэг өөр донороос элэг шилжүүлэн суулгах мэс засал, донороос (аллоген) цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ болон амьгүй донороос нүдний эвэрлэг, шөрмөс зэргийг шилжүүлэн суулгах эмчилгээг анх удаа амжилттай нэвтрүүлж нутагшуулах тал дээр ажиллаж байна.

Жилээс жилд эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчигээг хийж буй эмнэлэг, төв, баг, мэргэжилтнүүдийн тоо, эмчилгээ хийлгэж буй тохиолдлын тоо нэмэгдэхийн хэрээр мэргэжилтнүүдийг чадавхижуулах, байгууллага хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, эрдэм шинжилгээ, судалгаа хийх шаардлага төрөн гарч байна.

Уг хурлаар эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээний ололт амжилтыг дүгнэх, цаашид нэвтрүүлэх шинэ технологиудын талаар хэлэлцэх, Солонгос судлаач, эмч нараас туршлага судлахаас гадна энэ жилийн онцлог нь ёс зүйн талаас тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэхэд оршино.

Зорилго

Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний өнөөгийн байдал, мэргэжлийн болон ёс зүйн талаас тулгамдаж буй асуудлууд хэлэлцэн, ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж, туршлага солилцох

Зорилт

Дээрх зорилтын хүрээнд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй нийт эмч, мэргэжилтнүүдийн дунд 2023 оны 07 сарын 06 өдөр:

- БНСУ-ын зочин профессоруудын лекц (чиглэл тус бүрээр)
- Амьдрал бэлэглэж буй доноруудад болон үйлчлүүлэгчдэд хүндэтгэлтэй, ёс зүйтэй хандах, ёс зүйн талаас тулгамдаж буй асуудлуудаа хэлэлцэх
- Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний өнгөрсөн болон одоогийн хөгжлийн талаарх лекц
- Бөөр, элэг, цусны үүдэл эс болон бусад эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгасан эмчилгээний үр дүнгийн талаарх ололт амжилтууд
- Хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах
- Цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар лекцүүд уншигдана.

2023 оны 07 сарын 07 өдөр донорыг хүндэтгэх үйл ажиллагаа Сүхбаатарын талбайд явагдана.

Сургалтын хэлбэр: Лекц, эрдэм шинжилгээний хурал, донорыг хүндэтгэх нөхөрсөг үйл ажиллагаа

Хамрах хүрээ:

- ЭШС Монголын холбооны эмч, мэргэжилтнүүд
- ХСҮТ-ийн элэг шилжүүлэн суулгах багийн эмч, мэргэжилтнүүд
- Төрөлжсөн мэргэжлийн донор эмнэлгүүд (ШУГТЭ, ГССҮТ, УНТЭ, УХТЭ, бусад эмнэлгүүд)
- ЭХЭМҮТ-ийн эмч нар
- Эмгэг судлаач эмч нар
- Эмнэлзүйн эмгэг судлаач эмч
- Мэс заслын эмч нар
- Дотрын эмч нар
- Хүүхдийн эмч нар
- Сувилагч, тусгай мэргэжилтнүүд

Сургалтын арга барил: Танхим болон цахим хэлбэрээр явагдана.

Зохион байгуулагч: Эрхтэн Шилжүүлэн Суулгалтын Монголын Холбоо, Үүдэл эс шилжүүлэн суулгах баг

Үргэлжлэх хугацаа: 2023 оны 07 сарын 06-07 өдрүүдэд

Хаана: Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг, 4 давхрын хурлын их тэнхим

Олгох багц цаг: 2 багц цаг

Бүтээлд тавигдах шаардлага:

1. Хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалаар хийгдсэн судалгааны ажил, бүтээл байх.
2. Бүтээл бичих зааврыг чанд баримтлан ямар нэг техникийн болон үг, үсэг, өгүүлбэр зүйн алдаагүй байх.

Илтгэлийн хураангуйд тавигдах шаардлага:

1. Өгүүлэл/тохиолдол эх нь А4 цаасны нэг нүүр, Arial фондоор, гарчиг, дэд гарчиг үсгийн 12, текст нь үсгийн 11 хэмжээтэй, мөр хоорондын зай 1,15 sp, тал бүрээс 2 см зайтай.
2. Үгийн тоо нь өгүүллийн хураангуй, зураг, хүснэгт, ном зүйг оруулалгүйгээр 1000 үгэнд багтаан, нийт хуудасны тоо 5-с хэтрэхгүй байх.
3. Өгүүллийн гарчиг 100 хүртэл тэмдэгтийг агуулсан, товч гарчиг нь 50 хүртэл тэмдэгтийг агуулсан байх.
4. Судлаачдын нэрс, албан газрын харъяалал, гол судлаачийн и-мэйл хаягийг баруун талд бичих.
5. Судалгааны өгүүлэл нь товчлол /abstract/, оршил/удиртгал, материал арга зүй, үр дүн, хэлцэмж, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Судалгааны арга товч, тодорхой, оршил нь түүхчилсэн урт бус, утга санааг дахин давталгүй бичих.
6. Өгүүллийг сайтар нягталсан, математик, химийн томъёог шалгасан, алдаа мадаггүй байна.
7. Түлхүүр үг: 5 хүртэл байх.

8. Үндэслэл: Судалгааны ажлын судлагдсан байдал, үндэслэл, зорилго, дэвшүүлж буй гипотезисийг дэд гарчиг үүсгэхгүйгээр бичих.
9. Материал, арга зүй: Дэд гарчигуудын дор материал, арга зүйг бичнэ. Хасах болон оруулах шалгуур /Inclusion and exclusion criteria/ үзүүлэлтээ тусгаж өгнө. Статистикийн ямар программаар ямар үзүүлэлтийг тооцоолж гаргаснаа тусгах.
10. Үр дүн: Үр дүнг 4 хүртэлх тооны хүснэгт эсвэл зургаар илэрхийлнэ. Хэрэв түүнээс олон хүснэгт, зураг оруулах шаардлагатай бол хавсралтаар бичиж ирүүлнэ. Зурагт босоо, хэвтээ тэнхлэгийн утга, хэмжих нэгжийг зөв томъёолж бичсэн байх, фото зураг тод, зургийн нэрийг зургийн дор бичсэн байх.
11. Хэлцэмж: Практик зөвлөмж буюу судалгааны үр дүнгээс эмнэлзүйд нэвтрүүлсэн үйл ажиллагааг дүгнэж, хязгаарлагдмал байдлыг /limitation/ оруулах. Хэлцэмжийн төгсгөлд судалгаанаас гарсан үр дүнг хүүрнэх байдлаар бичих.
12. Ном зүй: 20 хүртэлх ном зүйг оруулна. Ном зүйг Ванкувер систем буюу тоон системээр бичнэ. Ишлэлийг [1] гэж тэмдэглэх ба ном зүйд байрлуулна.
13. Хураангуйн word file-ийн нэр: Криллээр илтгэгчийн нэр, доогуур зураас, гарчигийг бичнэ.
14. Хань илтгэлийн урт 180 см, өргөн нь 80 см хэмжээтэй байна. Times New Roman фонтоор, мөр хоорондын зай Single байна.

Материал хүлээн авах:

- Сүүлийн хугацаа: **2023 оны 06-р сарын 19-ны 17:00 цаг** хүртэл
- Email: mkot20230706@gmail.com
- Холбоо барих утас: 95346381, 96687536

Шалгуур үзүүлэлт:

1. 1-р шат:
 - 1.1. Шинжлэх ухаанч байдал
 - 1.2. Судалгааны бүтээлч санаа, шинэлэг тал
 - 1.3. Судалгааны ач холбогдол
 - 1.4. Судалгааны ажлын өгүүллэг бэлтгэсэн байдал
2. 2-р шат:
 - 2.1. Илтгэх чадвар
 - 2.2. Илтгэл бэлтгэсэн байдал /Постер бэлтгэсэн байдал/
 - 2.3. Цаг барилт
 - 2.4. Асуултанд хариулсан байдал

Шагналын сан:

Шилдэг 3 илтгэлийг шалгаруулан дараах байрыг эзлүүлнэ.

1. Тэргүүн байр 1 – Өргөмжлөл, 1.000.000 төгрөг
2. Хоёрдугаар байр 1 - Өргөмжлөл, 700.000 төгрөг
3. Гуравдугаар байр 1 - Өргөмжлөл, 500.000 төгрөг

Шилдэг ханын илтгэл шалгаруулан дараах байрыг эзлүүлнэ.

1. Тэргүүн байр-1- Өргөмжлөл, 500.000 төгрөг

Шалгаруулалтын зарчим:

1. Мэргэжлийн баг эхний шатны шалгаруулалтыг хийж, 2023 оны 06 сарын 26-ы дотор 5 аман илтгэл, 10 ханын илтгэл шалгаруулан, илтгэгч, судалгааны багт мэдээллэнэ.
2. Шалгарсан 5 илтгэлийг 2023 оны 07-р сарын 06-ны өдөр хэлэлцүүлэн шилдэг 3 илтгэлийг шалгаруулна.
 - Шалгарсан, хэлэлцүүлэгдэх илтгэлүүдийг 2023 оны 07 сарын 04-ний өдрийн 17:00 цагаас өмнө mkot20230706@gmail.com хаягаар хүлээн авна.
 - Илтгэх хугацаа 7 минут
3. Шалгарсан 10 ханын илтгэлээс шилдэг 1 ханын илтгэл шалгаруулна.
 - Шалгарсан, хэлэлцүүлэгдэх ханын илтгэлүүдийг 2023 оны 07 сарын 04-ний өдрийн 17:00 цагаас өмнө хүлээн авч байршуулна.

Mongolia-Korean 8th Organ Transplantation Congress Program

Congress theme: “Respect Ethics-Save Precious Lives”

2023.07.06

Time	Topic	Speaker
08.00-08.20	Registration	
08.20-08.30	Opening remarks & Introduction of the Guests: T.Munksaikhan (Health, Sports and Social Policy Advisor to the President of Mongolia) Curie Ahn (National Medical Center, Korea) D.Nyamsuren (Mongolian Organ Transplantation Association, Mongolia) N.Oyundelger (BMT, Organizing Committee, Mongolia)	
Session I. Moderator	Ethical Challenges in Organ Transplantation: N.Oyundelger (BMT, Organizing Committee, Mongolia) Sangil Min (Seoul National University Hospital, Korea)	
08.30-08.50	Current Situation and Future Trend of Organ Transplantation in Mongolia	D.Nyamsuren (Mongolian Organ Transplantation Association, Mongolia)
08.50-09.10	Ethical Challenges in Organ Transplantation in Asia	Curie Ahn (National Medical Center, Korea)
09.10-09.30	Transplantation Ethics Approved Guideline in Mongolia	D.Oyumbileg (Medical professional ethics committee, Ministry of Health, Mongolia)
09.30-09.50	Travel for Transplantation: Ethical Aspects	Benita Padilla (National Kidney and Transplant Institute, Philippines)
09.50-10.00	Q & A	Participants
10.00-10.20	Coffee Break	
Session II. Moderator	Improving Transplant Outcomes in Mongolia: D.Nyamsuren (Mongolian Organ Transplantation Association, Mongolia) Pyoeng Gyun Choe (Seoul National University Hospital, Mongolia)	
10.20-10.40	Current status and future trends of treatment for organ transplantation from deceased donors	P.Batchuluun (Center for Health Development, Mongolia)
10.40-11.00	Deceased Organ Donor Management	Hyunjae Im (National Cancer Center, Korea)
11.00-11.20	Kidney Transplantation Quality Indicator, Implementing Quality Checklist	Sangil Min (Seoul National University Hospital, Korea)
11.20-11.40	Liver Transplantation in NCC Mongolia	R.Munkhbat (National Cancer Center, Mongolia)
11.40-12.00	Liver Transplantation Quality Indicator	Young In Yoon (ASAN Medical center, Korea) (Online)
12.00-12.10	Q & A	Participants
12.10-12.20	Photo time	
12.20-13.20	Luncheon symposium	
Session III. Moderator	Infectious complication J.Sarantsetseg (Mongolian Organ Transplantation Association, Mongolia) Ki Seong Eom (Catholic University of Korea St. Mary’s Hospital, Korea)	
13.20-13.40	Vaccination for transplant recipients	O.Dashpagma (National Center for Communicable diseases, Mongolia)
13.40-13.55	Pre-transplantation infection evaluation	S.Myadagsuren (BMT, Mongolia)
13.55-14.15	Infectious complications after SOT	Pyoeng Gyun Choe (Seoul National University Hospital, Korea)
14.15-14.35	Infectious complications after BMT	Pyoeng Gyun Choe (Seoul National University Hospital, Korea)
14.35-14.45	Q & A	Participants
Session IV. Moderator	New Era of Transplantation in Mongolia P.Batchuluun (Center for Health Development, Mongolia)	

	Curie Ahn (National Medical Center, Korea)	
14.45-15.00	Pediatric Transplantation in Mongolia	B.Manduul (National Center for Maternal and Child Care, Mongolia)
15.00-15.20	Implementing Allo-BMT and National Bone Marrow Donor Program in Developing Country	Ki Seong Eom (Catholic University of Korea St. Mary's Hospital, Korea)
15.20-15.40	Implementing Heart Transplantation Program in Developing Country	Byung Chul Chang (Cha University Bundang Medical Center, Korea)
15.40-16.00	Current Technology and Future Trends of Histocompatibility and Immunogenetics in Transplantation	Borae G. Park (Korea Organ Donation Agency, Korea) (Online)
16.00-16.10	Q & A	Participants
16.10-16.30	Coffee Break	
Session V.	Mongolian doctors presentations	
16.30-16.37	Oral presentation-1	
16.37-16.44	Oral presentation-2	
16.44-16.51	Oral presentation-3	
16.51-16.58	Oral presentation-4	
16.58-17.05	Oral presentation-5	
17.05-17.15	Q & A	Participants
17.15-17.45	Poster presentation	
17.45-18.00	Discussion	
18.00-18.20	Award Ceremony and Closing	



“DONATE LIFE” EVENT PROGRAM

Date: July 7, 2023

From 1:00 pm to 4:00 pm

Place: Sukhbaatar square



Time	Programme	Comment
“Brain death determination team” workshop		
Ts. Ganbat (Consultant doctor of FCHM), Prof. Korea Hyungae Im (Korea)		
08:30-09:00	Visit to ICU, FCHM	
09:00-10:00	Management of Brain-Dead Donor in Korea. How to set up in Mongolia Donor organ preservation (What if there is a Brain-dead donor in rural areas?) Prof. Hyungae Im	The meeting hall of CHD
10:00-10:40	Case report /1 case from each team, in English/	Brain death determination team
10:40-12:00	Q&A	
“DONATE LIFE” event		
12:00-12:30	Receive guests	RDCTOT, CHD
12:30-12:40	Introduction of the Guests /P.Batchuluun Head of RDCTOT/	RDCTOT, CHD
13:00-13:10	Opening remarks D. Nyamsuren (Head of MOTA), S. Chinzorig (Minister of Health, Member of Parliament), J. Chinburen (Member of Parliament), B. Narantuya (Director of CHD), Curie Ahn (Member of TTS, General Secretary of AST), Dr Socorro Escalante (WHO Representative to Mongolia),Mongolian Rotary	RDCTOT, CHD
13:10-13:20	Art performance (National music ensemble)The band "Tenger Ayalguu"	RDCTOT, CHD
13:20-13:40	“Thank you doctor” performance (Representatives of recipients)	Recipient
13:40-13:50	Art performance Singer B. Enkhbat - "Khumuun demiin duulal"	Recipientr
13:50-14:00	Art performance	
14:00-14:10	An event to honor deceased donors	Video
14:10-14:15	1-minute silent tribute	Video
14:15-14:45	A religious event honoring deceased donors	
14:45-15:00	Greetings from the distinguished guests	
15:00-15:20	Event to honor donor hospitals	
15:20-15:30	Donor card	
15:30-15:50	Art performance	RDCTOT, CHD
15:00-16:00	Closing ceremony Walk around the Sukhbaatar statue	Create a logo and take photos

**МОНГОЛ-СОЛОНГОСЫН ХАМТАРСАН ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭН СУУЛГАЛТЫН
VIII ХУРАЛ**

УРИА: ЁС ЗҮЙГ ДЭЭДЛЭН-ЭРДЭНЭТ АМИЙГ АВАРЬЯ

2023.07.06

Хугацаа	Сэдэв	Илтгэгч
08.00-08.20	Бүртгэл	
08.20-08.30	Нээлтийн үйл ажиллагаа & Зочдын танилцуулга: Т.Мөнхсайхан (МУ-ын ерөнхийлөгчийн эрүүл мэнд, спорт, нийгмийн бодлогын зөвлөх, Монгол) Ан Гью Ри (Эрүүл мэндийн үндэсний төв, Солонгос) Д.Нямсүрэн (Эрхтэн шилжүүлэн суулгалтын Монголын холбооны тэргүүн, Монгол) Н.Оюундэлгэр (Үүдэл эс шилжүүлэн суулгах багийн ахлагч, Монгол)	
1-р хэсэг. Хурлын тэргүүлэгч	Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний ес зүйн асуудлууд: Н.Оюундэлгэр (Үүдэл эс шилжүүлэн суулгах багийн ахлагч, Монгол) Мин Сан Ил (Сөүлийн үндэсний их сургууль, Солонгос)	
08.30-08.50	Монголын эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага	Д.Нямсүрэн (Эрхтэн шилжүүлэн суулгалтын Монголын холбооны тэргүүн, Монгол)
08.50-09.10	Азийн эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний үеийн ес зүйн асуудлууд	Ан Гью Ри (Эрүүл мэндийн үндэсний төв, Солонгос)
09.10-09.30	Монгол улсад эрхтэн шилжүүлэн суулгах эмчигээний ес зүйн батлагдсан удирдамж	Д.Оюунбилэг (Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ес зүйн хорооны дарга, Монгол)
09.30-09.50	Эрхтэн шилжүүлэн суулгах зорилго бүхий аялал жуулчлал: Ёс зүйн асуудлууд	Бенита Падилла (Бөөр болон эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний нийгэмлэг, Филиппин)
09.50-10.00	Асуулт & Хариулт	
10.00-10.20	Цайны завсарлага	
2-р хэсэг. Хурлын тэргүүлэгч	Монгол улсад эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний үр дүнг сайжруулах нь: Д.Нямсүрэн (Эрхтэн шилжүүлэн суулгалтын Монголын холбооны тэргүүн, Монгол) Чуэ Пён Гюн (Сөүлийн үндэсний их сургууль, Солонгос)	
10.20-10.40	Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага	П.Батчулуун, (Эрүүл мэндийн хөгжлийн төв, Монгол)
10.40-11.00	Тархины үхэлтэй донорын менежмент	Им Хён Жэ (Хавдар судлалын үндэсний төв, Солонгос)
11.00-11.20	Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний чанарын үзүүлэлт, түүнийг хянах хяналтын хуудсыг нэвтрүүлэх нь	Мин Сан Ил (Сөүлийн үндэсний их сургууль, Солонгос)
11.20-11.40	Хавдар судлалын үндэсний төвд элэг шилжүүлэн суулгасан эмчилгээний өнөөгийн байдал	Р.Мөнхбат (Хавдар судлалын үндэсний төв, Монгол)
11.40-12.00	Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний чанарын үзүүлэлт	Юн Ён Ин (АСАН эмнэлэг, Солонгос) (Цахим)
12.00-12.10	Асуулт & Хариулт	
12.10-12.20	Зураг авалт	
12.20-13.20	Үдийн цай	
3-р хэсэг. Хурлын тэргүүлэгч	Халдварын хүндрэл: Ж.Саранцэцэг (Эрхтэн шилжүүлэн суулгалтын Монголын холбооны нарийн бичиг, Монгол) Ом Ги Сон (Католикийн их сургууль, Солонгос)	
13.20-13.40	Эрхтэн шилжүүлэн суулгах реципиентийн дархлаажуулалт	О.Дашпагма (Халдварт өвчин судлалын үндэсний төв, Монгол)

13.40-13.55	Эрхтэн шилжүүлэн суулгалтын өмнөх халдварын үнэлгээ	С.Мядагсүрэн (Үүдэл эс шилжүүлэн суулгах баг, Монгол)
13.55-14.15	Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний дараах халдварын хүндрэл	Чүэ Пён Гюн (Сөүлийн үндэсний их сургууль, Солонгос)
14.15-14.35	Цусны үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээний дараах халдварын хүндрэл	Чүэ Пён Гюн (Сөүлийн үндэсний их сургууль, Солонгос)
14.35-14.45	Асуулт & Хариулт	
4-р хэсэг. Хурлын тэргүүлэгч	Монгол улсын эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний чиг хандлага: П.Батчулуун, (Эрүүл мэндийн хөгжлийн төв, Монгол) Ан Гью Ри (Эрүүл мэндийн үндэсний төв, Солонгос)	
14.45-15.00	Монгол дахь хүүхдийн эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний өнөөгийн байдал ба чиг хандлага	Б.Мандуул (Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Монгол)
15.00-15.20	Хөгжиж буй орнуудад алло-ВМТ ба үүдэл эсийн донорын үндэсний программыг нэвтрүүлэх	Ом Ги Сон (Католикийн их сургууль, Солонгос)
15.20-15.40	Хөгжиж буй орнуудад зүрх шилжүүлэн суулгах программ нэвтрүүлэх	Жан Бён Чол (Ча их сургууль, Солонгос)
15.40-16.00	Эд нийцэл ба иммуногенетикийн технологийн өнөөгийн байдал, ирээдүйн чиг хандлага	Пак Гым Бурэ (Солонгосын донорын нэгдсэн агентлаг, Солонгос) (Цахим)
16.00-16.10	Асуулт & Хариулт	
16.10-16.30	Цайны завсарлага	
5-р хэсэг.	Эрхтэн шилжүүлэн суулгах салбарын судлаачдын илтгэлүүд	
16.30-16.37	Аман илтгэл-1	
16.37-16.44	Аман илтгэл-2	
16.44-16.51	Аман илтгэл-3	
16.51-16.58	Аман илтгэл-4	
16.58-17.05	Аман илтгэл-5	
17.05-17.15	Асуулт & Хариулт	
17.15-17.45	Ханын илтгэл танилцуулга	
17.45-18.00	Шилдэг илтгэл шалгаруулах үйл ажиллагаа	
18.00-18.20	Хаалтын үйл ажиллагаа	



“DONATE LIFE” ӨДӨРЛӨГИЙН ХӨТӨЛБӨР



Огноо: 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн

13:00-16:00 цагт

Газар: Сүхбаатарын талбай

Цаг	Үйл ажиллагаа	Тайлбар
Тархины үхэл тодорхойлох баг чадавхжуулах workshop УНТЭ-ийн ЭЭТ-ийн зөвлөх эмч Ц.Ганбат, Проф. Korea Hyungae Im		
08:30-09:00	УНТЭ-ийн ЭЭТ-тай танилцах	
09:00-10:00	Тархины үхэлтэй донорын менежментийн өнөөгийн байдал,эрхтэн хамгаалах эмчилгээг хэрхэн хийх вэ? /Prof. Hyungae Im/	ЭМХТ-ийн хурлын заал
10:00-10:40	Тохиолдолд суурилсан ррт /Баг бүрээс 1 тохиолдол, англи хэл дээр/	ТҮТБ
10:40-12:00	Асуулт хариулт	
“DONATE LIFE” өдөрлөг Сүхбаатарын талбай		
12:00-12:30	Зочдыг хүлээж авах	
12:30-12:40	Зочдыг танилцуулах /ЭМХТ, ЭЭЭШСҮАЗА-ны дарга П.Батчулуун танилцуулна./	
13:00-13:10	Нээлтийн үйл ажиллагаа ЭШСМХ-ны тэргүүн Д.Нямсүрэн, ЭМС УИХ-ын гишүүн С.Чинзориг, УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн, ЭМХТ-ийн захирал Б.Нарантуяа, TTS —ийн төлөөлөгч, АСТ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга Curie Ahn, ДЭМБ-ийн суурин төлөөлөгч Др.Сокорро Эскаланте, Монголын Ротаричуудын төлөөлөл,	ЭМХТ, ЭЭЭШСҮАЗА
13:10-13:20	Урлагийн тоглолт /Үндэсний хөгжмийн чуулга/“Тэнгэр аялгуу” хамтлаг	ЭМХТ-ийн ЗА
13:20-13:40	Эрхтний донорын талаар эмч нарт талархал илэрхийлэхарга хэмжээ /Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийлгэсэн иргэдийнтөлөөлөл сэтгэгдэл хэлнэ/	Амьд болон амьгүй донороос ЭШС иргэд
13:40-13:50	Урлагийн тоглолт /дуу/ “Хүмүүн дэмийн дуулал” Дуучин МУСТА Б.Энхбат	ЭШСИХ
13:50-14:00	Урлагийн тоглолт /шүлэг/	
14:00-14:10	Амьгүй доноруудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ	Видео бичлэг
14:10-14:15	Амьгүй доноруудад хүндэтгэл үзүүлэх ёслол /1 мин чимээгүй хүндэтгэл үзүүлэх/	Видео бичлэг
14:15-14:45	Шашны төлөөлөл амьгүй доноруудад хүндэтгэл үзүүлэх аргахэмжээ	
14:45-15:00	Хүндэт зочдоос мэндчилгээ дэвшүүлэх	
15:00-15:20	Донор эмнэлгүүдэд Хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ	
15:20-15:30	Донорын зөвшөөрлийн карт гардуулах үйл ажиллагаа	
15:30-15:50	Урлагийн тоглолт /дуу/	ЭМХТ, ЭЭЭШСҮАЗА
15:00-16:00	Хаалтын арга хэмжээ Сүхбаатарын хөшөө нар зөв тойрч алхах	Лого үүсгэж зураг авхуулах